

Байгаль орчин, ногоон хөгжил, аялал  
жуулчлалын сайдын 2016 оны ..... сарын  
.....-ны өдрийн ..... дугаар тушаалын  
.....дүгээр хавсралт

## **ОЙГООС МОД БЭЛТГЭХ ЖУРМЫН ТӨСӨЛ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү журмын зорилго нь Ойн тухай хуулийн хэрэгжилтийг хангахад ойгоос мод бэлтгэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2. Ойгоос мод бэлтгэх ажлыг төлөвлөх, мод огтлох, тээвэрлэх болон хяналт тавих үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

1.3. Энэхүү журманд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурьдсан утгаар ойлгоно.

1.3.1. "Ойгоос мод бэлтгэх" гэж Ойн тухай хууль тогтоомжийн дагуу төлбөр хураамжийг төлж, эрхийн бичиг авсны үндсэн дээр ойгоос модыг огтолож мөчиртэй болон мөчирлөсөн туушаар эсвэл сортиментээр цагаалах, хураах, мөчир, гишүү, үлдэгдлийг цуглуулж талбайг цэвэрлэх зэрэг бэлтгэсэн модыг доод агуулахад хүргэх хүртэлх цогц үйл ажиллагааг;

1.3.2. "Арчилгааны огтлолт" гэж зулзаган ойн титэм нийлэх үеэс эхлэн ашиглалтын нас хүртэлх хугацаанд түүний бүтэц, бүрэлдэхүүн, шигүүрлийг зохицуулж, модны өсөлтийг нэмэгдүүлэх зорилгоор модыг үе шаттайгаар сонгон огтлохыг;

1.3.3. "Цэвэрлэгээний огтлолт" гэж түймэр, хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэний улмаас үхжиж хатсан босоо модыг хөнөөлт шавж, өвчний голомт үүсэх нөхцлийг хаах, ой дахь шатах материалын хуримтлалыг багасгах, модны чанарыг муудахаас өмнө авч ашиглах зорилгоор нэлэнхүйд нь болон түүвэрлэн огтлохыг;

1.3.4. "Үйлдвэрлэлийн ашиглалтын огтлолт" гэж ашиглалтын бүсийн ойгоос үйлдвэрлэлийн зориулалтаар нас гүйцсэн ургаа мод огтлохыг;

1.3.5. "Ойн цэвэрлэгээ" гэж Ойн тухай хуулийн 3.1.15-д заасныг;

1.3.6. "Хяналт тавих" гэж ойгоос мод бэлтгэх үйл ажиллагаа Байгаль орчныг хамгаалах тухай, Ойн тухай, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, тогтоомжид нийцэж байгаа эсэх;

1.3.7. "Уламжлалт бүтээгдэхүүн" гэж мод болон түүний үндэс, ур, үйс, холтсыг ардын уламжлалт аргаар боловсруулж бэлтгэсэн хөгжмийн зэмсэг, гэрийн мод, мал аж ахуйн тоног хэрэгсэл, хүүхдийн тоглоом наадгай, сав суулга, бэлэг дурсгал, чимэглэлийн бүтээгдэхүүнийг;

### **Хоёр. Ойгоос бэлтгэх модны хэмжээг тогтоох**

2.1 Сум, дүүргийн Засаг дарга нь дараа жилд бэлтгэх модны талаарх саналаа сумын ойн менежментийн төлөвлөгөө, ойн мэргэжлийн байгууллага, ойн санг гэрээгээр эзэмшигч аж ахуйн нэгж, нөхөрлөлийн болон иргэдийн ахуйн болон уламжлалт бүтээгдэхүүн үйлдвэрлэх зориулалтаар бэлтгэх модны талаарх багийн Засаг даргын саналыг үндэслэн аймаг нийслэлийн Засаг даргад тухайн оны 5 дугаар сарын 01-ний дотор хүргүүлнэ.

